



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/506

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн тооцсугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД  С.ЭНХБОЛД

141222462

Эрүүл мэндийн сайдын 2022-оны 10
дугаар сарын 14-ны өдрийн 4/06
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэг дсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянзүрх дүүрэг, Миний зөвлөгч өрхийн эрүүл мэндийн төв	337/2022	3 жил	2022.10.27	2025.10.27
2.	Баян-өлгий аймаг, Дэлүүн сумын эрүүл мэндийн төв	338/2022	1 жил	2022.10.13	2023.10.13
3.	Дархан-уул аймаг, Мэдс-Тоб өрхийн эрүүл мэндийн төв	339/2022	3 жил	2022.10.27	2025.10.27
4.	Завхан аймаг, Ургамал сумын эрүүл мэндийн төв	340/2022	2 жил	2022.10.15	2024.10.15
5.	Завхан аймаг, Завханмандал сумын эрүүл мэндийн төв	341/2022	3 жил	2022.10.15	2025.10.15
6.	Завхан аймаг, Түдэвтэй сумын эрүүл мэндийн төв	342/2022	3 жил	2022.10.15	2025.10.15
7.	Завхан аймаг, Сонгино сумын эрүүл мэндийн төв	343/2022	2 жил	2022.10.15	2024.10.15
8.	Өмнөговь аймаг, Бүтэнжаргал эмнэлэг	344/2022	2 жил	2022.10.27	2024.10.27
9.	Сэлэнгэ аймаг, Эмнэх өрхийн эрүүл мэндийн төв	345/2022	3 жил	2022.10.29	2025.10.29
10.	Сэлэнгэ аймаг, Номтхан өрхийн эрүүл мэндийн төв	346/2022	3 жил	2022.10.29	2025.10.29
11.	Сэлэнгэ аймаг, Асгатын дов ХХК-ийн эмнэлэг	347/2022	2 жил	2022.10.29	2024.10.29
12.	Төв аймаг, Мон аврагас ХХК-ийн Эх булаг сувилал	348/2022	3 жил	2022.10.29	2025.10.29

оо0оо